



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

**Төрийн болон орон нутгийн өмчид эд  
хөрөнгө бүртгэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон 14 нэрийн, нийт 21,272,237,379.00 (хорин нэгэн тэрбум хоёр зуун далан хоёр сая хоёр зуун гучин долоон мянга гурван зуун далан есөн) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Нийслэлийн өмчийн харилцааны дарга, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.3. Хөрөнгийн давхар бүртгэлийг залруулах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137004570  
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 03 дугаар сарын 17 ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ /ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ/-ЭЭР БАРЬСАН  
 ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ /БАРИЛГА БАЙГУУЛАМЖ/-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөг/	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Эрүүл мэндийн төвийн барилга (Ховд аймаг Чандмань сум)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, хоёрдугаар ангилалын 15 ортой,	956,862,748.00	2019.08.16	A/482/11/2019	Ховд аймаг, Эрүүл мэндийн төв (Чандмань сум)
2	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо)	Эрүүл мэндийн төвийн зориулалттай, бага зэргийн төвөгшилтэй ангилалын 2 давхар 12.4x20.4м, 6.10x10.2м барилга	580,182,980.00	2020.09.11	БА-035/2020	Нийслэл, Өрхийн эрүүл мэндийн төв (Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо)
3	Эрүүл мэндийн төвийн барилга (Завхан аймаг Алдархаан сум)	15 ортой, дунд төлөвшилтэй ангилалын зоорьгүй, 1 давхар	1,184,822,317.00	2020.12.01	48/2020	Завхан аймаг, Эрүүл мэндийн төв (Алдархаан сум)
4	Сүрьеэгийн эмнэлгийн барилга (Хэнтий аймаг Хэрлэн сум)	Бага зэргийн төвөгшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар, 20 ортой, 32x16.3м	1,993,179,243.00	2020.12.10	108/2020	Хэнтий аймаг, Нэгдсэн эмнэлэг (Хэрлэн сум)
5	Эрүүл мэндийн төвийн барилга (Сүхбаатар аймаг Наран сум)	Дунд ангилалын төлөвшилтэй, 10 ортой,	782,460,101.00	2019.08.12	СҮ-009/19	Сүхбаатар аймаг, Эрүүл мэндийн төв (Наран сум)
6	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо)	Бага төвөгшилтэй ангилалын зоорьтой, 2 давхар, 20 ортой, 32x16.3м	1,600,000,000.00	2022.03.01	БА-051/2022	Нийслэл, Өрхийн эрүүл мэндийн төв (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо)
7	Эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар, Хан Уул дүүрэг 14-р хороо)	Бага төвөгшилтэй ангилалын зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 14x18м	1,337,903,897.00	2022.12.21	БА-284/2022	Нийслэл, Эрүүл мэндийн төв (Улаанбаатар, Хан Уул дүүрэг 14-р хороо)

8	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга (Баян-өлгий аймаг, Улаан хус сум)	Бага төвөгшилтэй ангилалын зоорьгүй, 1 давхар, тэнхлэгээрээ 21x11.4м	332,590,584.00	2021.11.24	19/2021	Баян-Өлгий аймаг, Эрүүл мэндийн төв (Улаан хус сум)
9	Эрүүл мэндийн төвийн барилга (Дундговь аймаг, Хулд сум)	Дунд ангилалын төлөвшилтэй, 10 ортой, хагас зоорьтой, 2 давхар, 33x12.4м	1,240,781,830.00	2020.12.01	41/2020	Дундговь аймаг, Эрүүл мэндийн төв (Хулд сум)
10	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Хөвсгөл аймаг, Мерен сум, 1, 2-р баг)	1 давхар, зоорьгүй, тэнхлэгээрээ 12x21м	667,436,467.00	2022.11.23	ББКД-67-50/22	Хөвсгөл аймаг, Энх үйлс өрхийн эрүүл мэндийн төв (Мерен сум)
11	Эмнэлгийн барилга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21-р хороо)	Дунд төвөгшилтэй, зоорьтой, 4 давхар, 50 ортой, А блок 12.8x21.3, Б блок 15x32м	4,926,190,707.00	2021.11.24	БА-244/2021	Нийслэл, Эрүүл мэндийн төв (Баянзүрх дүүрэг)
12	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ортой (Баян-өлгий аймаг, Өлгий сум)	Дунд зэргийн төвөгшилтэй, 50 ортой, 4 давхар, зоорьтой, А блок, Б блок	5,015,598,916.00	22020.12.18	47/2020	Баян-Өлгий аймаг, Аймгийн нэгдсэн эмнэлэг
13	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга (Хэнтий аймаг, Баян-Адрага сум)	2 давхар, тэнхлэгээрээ зоорьгүй, 13.5x13.5м	359,451,489.00	2019.12.31	7182019	Хэнтий аймаг, Эрүүл мэндийн төв (Баян-Адрага сум)
14	Эрүүл мэндийн төвийн барилга (Баян-өлгий аймаг, Ногооннуур сум, Ховд баг)	Дунд зэргийн төвөгшилтэй, 1 давхар, зоорьгүй, 5 ортой, 9x18м.	294,776,100.00	2021.12.31	25/2021	Баян-өлгий аймаг, Эрүүл мэндийн төв (Ногоон нуур сум)
			21,272,237,379.00			
НИЙТ ДҮН			(хорин нэгэн тэрбум хоёр зуун далан хоёр сая хоёр зуун гучин долоон мянга гурван зуун далан есөн төгрөг)			